



УЛААНБААТАР ХОТ

“Хүн ам зүй, шилжилт хөдөлгөөн ба хэрэгцээ
шаардлага” Түргэвчилсэн судалгаа-

2022 оны 6-8 сар (Хоёр дугаар ээлжийн тоон мэдээлэл нэгтгэл)



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарын хөгжлийн агентлаг

АГУУЛГА

Удиртгал ба арга зүй.....	1
Мэдээллийн дүн шинжилгээ - Улаанбаатар	4
1.1 Хүн амын суурь тоон үзүүлэлт ба хүн ам зүйн тойм	4
1.2 Бүртгэл.....	5
1.3 Ирсэн иргэд.....	7
1.4 Явсан иргэд.....	10
1.5 Хөдөлмөр эрхлэлт.....	12
1.6 Санхүүгийн нөхцөл байдал.....	12
1.7 Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тулгамдаж буй асуудлууд.....	14
1.8 Үйлчилгээний хүртээмж ба дэд бүтэц.....	16
Дүгнэлт ба Зөвлөмж	19
Хавсралт	21

УДИРТГАЛ БА АРГА ЗҮЙ

УДИРТГАЛ

Энэхүү судалгаа нь Улаанбаатар хотын хүн ам зүй, шилжилт хөдөлгөөн ба хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход чиглэсэн үндсэн сэдвүүдийн хүрээнд 2022 оны 6, 7, 8 дугаар сарын тойм мэдээллийг харуулсан болно. Уг судалгаа нь Монгол дахь ОУШХБ-аас Улаанбаатар хотод хийсэн хөдөлгөөнийг тандах ДТМ судалгааны аргачлалын хоёр дахь удаагийн тоон мэдээлэл нэгтгэлийн үе шат юм.

Нэгдүгээр шатны тоон мэдээлэл нэгтгэлийн адил энэхүү судалгаагаар Улаанбаатар хотын хэмжээнд хүн амын бодит тоон мэдээлэл, суурь тоон үзүүлэлт, шилжин ирэгсэд ба явагсад (шилжилт хөдөлгөөн), хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн нөхцөл байдал, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тулгамдаж буй асуудлууд, үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц гэсэн найман үндсэн сэдвийг авч үзсэн болно. Тоон мэдээллийг Улаанбаатар хотын хамгийн жижиг засаг захиргааны нэгж болох хэсгийн¹ нутаг дэвсгэрийн нөхцөл байдал, мэдээлэл нэгтгэгчийн мэдлэгийн нөөц бололцоо, мэдээллийн нээлттэй байдлаас хамааран хэсгийн ахлагч нараар тандалт судалгаа, ярилцлага хийх замаар нэгтгэсэн болно.

Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (ОУШХБ)-ын өмнөх судалгаануудаас харахад газрын доройтол, уур амьсгалын өөрчлөлт зэрэг хүчин зүйлс Монгол Улсын уламжлалт амьдралын хэв маягийг өөрчилж байгааг бидний хийсэн өмнөх судалгаанууд тогтоосоор байна. Ган, зудын² давтамж нэмэгдэж, ажлын байр цөөн, амьдрах орчин нөхцөл хангалтгүй, хөдөөгийн хүн амын мал аж ахуйгаас хараат байдал зэрэг нь суурин газар болон бусад аймаг³ орон нутаг руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлэх хүчин зүйл болсоор байна.

Тэдгээр шилжих хөдөлгөөний үндсэн шинж чанарыг ойлгоход Монгол Улсын хэмжээнд

¹ Хэсэг гэдэг нь Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хамгийн жижиг засаг захиргааны нэгж юм.

² Зуд гэдэг нь зуны дэлгэр цагт бороо хур дутмаг, тариа ногоо ургац муутай гандуу байсантай холбогдуулан өвөл өвс тэжээл дутагдах, мал идэх өвсгүй болж өвөлжилт хүндрэхийг хэлнэ.

³ Аймаг нь Монгол Улсын хөдөө орон нутгийн засаг захиргааны анхдагч нэгж хэлнэ.

өөр өөр байрилд ажиллаж амьдарч, шилжилт хөдөлгөөнд оролцож буй хүн амын бодит тоон мэдээлэл шаардагдах бөгөөд мэдээллийн зөрүүтэй байдал үндсэн шинж чанарыг ойлгоход саад болж байна. Энэхүү судалгаа нь Улаанбаатар хотын хүн ам, шилжилт хөдөлгөөний бодит мэдээллийг олж авах замаар энэ хоёр мэдээлэл хоорондын зөрүүг арилгаж дотоодын шилжилт хөдөлгөөний талаарх бодлого, үйл ажиллагааг бодит мэдээллээр хангах, мэдээллийн баазыг нэмэгдүүлэх зорилготой.

СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

Энэхүү тайланд Монгол Улс дахь ОУШХБ-ын Шилжилт хөдөлгөөнийг тандах матриц (ДТМ)-ийн аргыг үндэслэн боловсруулсан хөдөлгөөнийг тандах (МТ) дэд аргачлалыг ашигласан болно.

Судалгаанд Улаанбаатар хотын хамгийн жижиг засаг захиргааны нэгж болох хэсгийн түвшинд хэсгийн ахлагч нараар дамжуулан тоон мэдээллийг нэгтгэсэн. Хэсгийн ахлагч нар өөрийн нутаг дэвсгэрийн иргэдтэй ярилцах, ажиглалт хийх, өөрсдийн бусад нөөц бололцоог ашиглах болон харилцаа холбооны хэрэгслүүдийг ашиглан тоон мэдээллийг нягтлах, баталгаажуулах ажлыг хийсэн. Хэсгийн ахлагч нарыг судалгааны агуулга тус бүрээр нь ялган эрэмбэлсэн найман үндсэн сэдвийг багтаасан судалгааны агуулгыг/хэрэгслийг нөхөхийг хүссэн юм. Тэд Кобо программ хангамжаар дамжуулан тоон ажиглалт, баталгаажуулалт хийгдсэн мэдээллийг гар утас эсвэл таблет ашиглан цахим системд нөхөж илгээсэн. Мэдээллийг зөв, чанартай нэгтгэхийн тулд судалгааг хэрэгжүүлэхээс өмнө хэсгийн ахлагч нарыг судалгааны асуулгын дэлгэрэнгүйг ойлгох, тандалт судалгааг хийх арга аргачлалыг багтаасан сургалтад хамруулсан. Түүнчлэн ДТМ судалгааг хариуцсан ажилтнууд мэдээлэл нэгтгэх явцад үүссэн аливаа асуулт, асуудалд цаг тухайд нь хариу өгч бэлэн байдалд ажилласан юм.

Өгөгдлийг системд нэгтгэх үйл явц албан ёсоор хаагдамагц ДТМ-ийн судалгааны баг бүрэлдэхүүн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажлыг эхлүүлсэн бөгөөд гарч болзошгүй алдаа, тоон мэдээллийн зөрүү, давхардал зэргийг илрүүлэхийн тулд өгөгдлийн

хяналтын шатанд чанарын баталгаажуулалтын шалгалтыг сонгогдсон дүүргүүд дээр хийсэн. Тоон мэдээллийн өгөгдөлтэй холбоотой аливаа асуудал илэрсэн тохиолдолд ДТМ-ийн баг тодруулга авахаар хэсгийн ахлагч нартай утсаар холбогдож тоон мэдээллийг тодруулж, шаардлагатай өөрчлөлтийг оруулан баталгаажуулсан байна. Хяналт шалгалтыг хийж дууссаны дараа мэдээлэлд дүн шинжилгээ хийх үе шатанд шилжсэн. Судалгааны үр дүнг хэсгийн түвшинд дүн шинжилгээ хийж дараа нь хороо,⁴ дүүрэг, Улаанбаатар хотын түвшинд нэгтгэн дүгнэв. Иймээс энэхүү тайланд тусгагдсан аливаа үр дүнг хэсгийн түвшинд нягтлан харах боломжтой гэдгийг дурдах нь зүйтэй юм.

ХЯЗГААРЛАГДМАЛ БАЙДАЛ

Энэхүү судалгаанд ашигласан аргачлал нь үндсэн мэдээлэгч нараас өгсөн мэдээлэлд дүн шинжилгээ хийж байгаа төдийгүй бусад эх сурвалжтай гуравласан өгөгдлийн санг бий болгох үндсэн зорилготой юм.

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Газрын зураг 1. Улаанбаатар хотын газрын зураг



⁴ Хороо гэдэг нь Улаанбаатар хотын засаг захиргааны нэгж юм.

Хүснэгт 1. Тоон мэдээлэл нэгтгэх үеийн Улаанбаатар хотын хүн амын тоо

Дүүрэг	Хэсгийн тоо	Хүн амын тоо (бүртгэлгүй түр оршин суугчдын мэдээллийг багтаасан)
Баянзүрх	519	417,251
Сонгинохайрхан	370	345,292
Баянгол	250	240,197
Хан-Уул	220	226,628
Чингэлтэй	202	151,647
Сүхбаатар	179	134,349
Налайх	50	41,673
Багануур	34	29,317
Багахангай	6	5,021
Нийт	1,830	1,591,375

НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Хүн амын суурь тоон үзүүлэлт: Гарал үүсэл, бичиг баримт, хууль эрх зүйн нөхцөл байдал, бүртгэл, нас, хүйс, нийгэм-хүн ам зүйн шинж чанараас үл хамааран үнэлгээ хийх үед тухайн байршилд байгаа бүх оршин суугч.

Өрх: Нэг дээвэр дор амьдардаг, зардал болон хоол хүнсээ хуваалцдаг бүлэг хүмүүс.

Ирсэн иргэд: Улаанбаатар хот дотор эсвэл хотын гаднаас ирсэн эсэхээс үл хамааран хамгийн багадаа дөрвөн долоо хоног болон түүнээс дээш хугацаагаар оршин суух зорилготой хотын ямар нэг байршилд ирсэн хүмүүс (шилжилт хөдөлгөөн, түр оршин суух бүртгэл зэргийг хийлгэсэн эсэхээс үл хамаарна).

Явсан иргэд: Улаанбаатар хот дотор эсвэл хотын гадагшаа явсан эсэхээс үл хамааран хамгийн багадаа

дөрвөн долоо хоногийн туршид буцах бодолгүй, аль нэг байршилд явсан хүмүүс (шилжилт хөдөлгөөн, түр оршин суух бүртгэл зэргийг хийлгэсэн эсэхээс үл хамаарна).

Мэдээлэгч: Мэдээллийн эх сурвалж бөгөөд энэ судалгаанд Улаанбаатар хотын нийт хэсгийн ахлагч нарыг хэлнэ.

Мэдээлэл нэгтгэгч: Мэдээлэл нэгтгэж буй хүн. Энэхүү үнэлгээнд үндсэн мэдээлэгч нар мэдээлэл нэгтгэсэн тул эдгээр хоёр нэр томьёо давхцана.

Гэр хороолол болон орон сууц зонхилсон хэсэг: Засаг захиргааны хамгийн жижиг хэсэгт улсаас халаалт, цэвэр усаар хангагдсан орон сууц, зөөврийн усаар хэрэгцээгээ хангадаг, мод, нүүрс түлж гэрээ дулаацуулдаг гэр хороолол зэрэгцэн оршдог хэсгийг хэлнэ.

1. МЭДЭЭЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ – УЛААНБААТАР ХОТ

1.1 ХҮН АМЫН СУУРЬ ТООН ҮЗҮҮЛЭЛТ БА ХҮН АМ ЗҮЙН ТОЙМ



463,267

Өрх



1,591,375

Хувь хүн



57%

Хөдөлмөрийн насны иргэд



34%

Хүүхэд



9%

Өндөр настан



53%

Эмэгтэй



47%

Эрэгтэй



24,644

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн



16,677

Асран хамгаалагчгүй ахмад настан



12,726

Жирэмсэн эмэгтэй



14,716

Эцэг, эхийнхээ аль нэгээс тусгаарлагдсан хүүхэд



15,744


Өрх толгойлсон эцэг, эхтэй өрх



49,421

60 ба түүнээс дээш насны өрхийн тэргүүлэгчтэй өрх

Зураг 1. Хүн ам зүй (эзлэх хувь насны бүлгээр)




Үнэлгээ хийх үед (2022 оны 6, 7, 8-р саруудад), Улаанбаатар хотод 1,591,375 иргэн, 462,276 өрх амьдарч байсан. Үүнээс 47 хувь нь эрэгтэй, 53 хувь нь эмэгтэй байв. Хүн амын 34 хувь нь хүүхэд гэж бүртгэгдсэнээс 11 хувь нь 0-5 насны, 23 хувь нь 6-17 насныхан байна. Хүн амын 57 хувийг 18-59 насны насанд хүрэгчид, 9 хувийг 60-аас дээш насны ахмад настнууд эзэлж байна.

Нийтдээ 24,644 хүн хөгжлийн бэрхшээлтэй (хүн амын 5 хувь), 12,726 эмэгтэй жирэмсэн (эмэгтэйчүүдийн 2 хувь), 16,677 ахмад настан (60 ба түүнээс дээш насныхны 12 хувь), 14,716 хүүхэд эцэг, эхийн аль нэгээс эсвэл аль алинаас тусгаарлагдсан (18-с доош насны хүүхдүүдийн 3 хувь) гэж бүртгэгджээ. Түүнчлэн, Улаанбаатар хотын хэмжээнд 15,744 өрх толгойлсон эцэг, эхтэй өрх (нийт өрхийн 3 хувь), 60 ба түүнээс дээш насны өрхийн тэргүүлэгчтэй 49,421 өрх⁵ (нийт өрхийн 11 хувь) тус бүр бүртгэгдсэн байна.

Улаанбаатар хот 9 дүүрэгтэй. Хотын хэмжээнд хамгийн олон хүн амтай гурван дүүрэгт Баянзүрх (нийт хүн амын 26 хувь), Сонгинохайрхан (22 хувь), Баянгол (15 хувь) багтжээ. Харин хамгийн цөөн хүн амтай гурван дүүрэг нь Налайх (нийт хүн амын 3 хувь), Багануур (2 хувь), Багахангай (нийт хүн амын 0.3 хувь) байв.

Зураг 2, Хүн ам зүй, дүүргээр (эзлэх хувь)




1.2 БҮРТГЭЛ

Улаанбаатар хотын нийт нутаг дэвсгэрийн (хэсэг) 42 хувьд оршин суугаа газартаа бүртгэлээ хийлгэсэн байдал 90 буюу түүнээс дээш хувьтай, харин нийт хэсгийн 7 хувь нь буюу 124 хэсэг оршин суугаа газартаа бүртгэлээ хийлгэсэн байдал 100 хувьтай байна. Мөн түүнчлэн Улаанбаатар хотын нийт хэсгүүдийн 45 хувь нь ихэнх иргэд оршин суугаа

газартаа бүртгэлээ хийлгэсэн (61-89 хувь), нийт хэсгийн 10 хувь нь тал нь оршин суугаа газартаа бүртгэлээ хийлгэсэн (40-60 хувь) гэж мэдээлсэн бол үлдсэн 3 хувь нь оршин суугчдын 40-с доош хувь нь оршин суугаа газартаа бүртгэлээ хийлгэсэн байдал гэж мэдээлжээ. Үүнд оршин суугаа газартаа бүртгэлээ хийлгэсэн байдал нь 0% байгаа 6 хэсэг (0.3 хувь) багтсан болно.

Зураг 3. Оршин суух бүртгэл (хэсэгт эзлэх хувь)



⁵ Өрхийн тэргүүн нь 60 ба түүнээс дээш насны хүнтэй өрх

**Зураг 4. Оршин суух бүртгэл 100% хийгдсэн
(дүүрэгт эзлэх хувь)**



**Зураг 5. Оршин суух бүртгэл 90%-99% хийгдсэн
(дүүрэгт эзлэх хувь)**



**Зураг 6. Оршин суух бүртгэл 40%-89% хийгдсэн
(дүүрэгт эзлэх хувь)**



**Зураг 7. Оршин суух бүртгэл 40%-с доош хийгдсэн
(дүүрэгт эзлэх хувь)**



Улаанбаатар хотын бүх дүүргүүдэд бүртгэл хийлгээгүй үндсэн шалтгаан өөрсдийгөө тухайн хэсэгт түр зуур оршин сууж байгаа гэж үзэж буй иргэд байсан ба энэ нь хотын хэмжээнд (хэсгүүдийн 26 хувь) бүртгэл хийлгэхгүй байх гол шалтгаан

болсон.Бүртгүүлэхгүй байх бусад шалтгаанд сургууль/боловсрол эзэмших (14 хувь), бүртгүүлэх хэрэгцээ шаардлагын тухай ойлголтгүй иргэд (12 хувь), бүртгэлийн маягтуудыг хэрхэн бөглөхийг мэдэхгүй (9 хувь) гэсэн шалтгаанууд багтжээ.

Зураг 8. Бүртгэл хийлгэхгүй байгаа үндсэн шалтгаан (эзлэх хувь)



Зураг 9. Түр зуур оршин сууж байгаа гэж үзэн бүртгэл хийлгэдэггүй гэж хамгийн ихээр мэдээлсэн дүүргүүд (эзлэх хувь)



1.3 ИРСЭН ИРГЭД


Тоон мэдээлэл нэгтгэхээс өмнөх гурван сарын хугацаанд Улаанбаатар хотод нийт 47,309 иргэн ирсэн нь нэг дүгээр шатны тоон мэдээлэл тоон нэгтгэлийн үзүүлэлтээс (119,914) харьцангуй буурсан үзүүлэлттэй байна. Ирсэн иргэдийн

хамгийн өндөр хувийг Сонгинохайрхан дүүрэг (22 хувь), Баянзүрх дүүрэг (21 хувь), Хан-Уул дүүрэг (19 хувь) эзэлж байгаа бол өмнөх удаагийн тоон мэдээлэл нэгтгэлээр Баянзүрх дүүрэг (24 хувь), Сонгинохайрхан дүүрэг (21 хувь), Хан-Уул дүүрэг (17 хувь) байжээ.⁶


Зураг 10. Ирсэн хөдөлгөөн хамгийн их бүртгэгдсэн дүүргүүд (эзлэх хувь)




Зураг 11. Сонгинохайрхан дүүрэгт ирсэн хөдөлгөөн хамгийн их бүртгэгдсэн хороод - (эзлэх хувь)




Зураг 12. Баянзүрх дүүрэгт ирсэн хөдөлгөөн хамгийн их бүртгэгдсэн хороод - (эзлэх хувь)




Зураг 13. Хан-Уул дүүрэгт ирсэн хөдөлгөөн хамгийн их бүртгэгдсэн хороод - (эзлэх хувь)



Зураг 14. Баянгол дүүрэгт ирсэн хөдөлгөөн хамгийн их бүртгэгдсэн хороод - (эзлэх хувь)



Зураг 15. Сүхбаатар дүүрэгт ирсэн хөдөлгөөн хамгийн их бүртгэгдсэн хороод - (эзлэх хувь)




⁶ Улаанбаатар хот "Хүн ам зүй, шилжилт хөдөлгөөн ба хэрэгцээ шаардлага" Түргэвчилсэн судалгаа тайлангийн өмнөх тайланг үзнэ үү.

Улаанбаатар хотод ирсэн иргэдийн дийлэнх буюу 70 хувь нь нийслэлийн өөр дүүрэг/хорооноос ирсэн бол үүний араас тус дүүргийн өөр хороо/хэсгээс ирэгсэд (16 хувь), хөдөө орон нутгаас ирэгсэд (14 хувь) оржээ. Улаанбаатар хот доторх шилжилт хөдөлгөөн нэмэгдсэн асуудал нь сургууль, цэцэрлэгийн бүртгэлтэй холбоотойгоор хийгдсэн гэж ойлгогдохоор харагдаж байна.

Учир нь сургууль, цэцэрлэгийн бүртгэлийн ажил Монгол Улсад 8 сард идэвхэждэг бөгөөд иргэдийн хот доторх шилжилт хөдөлгөөний бүртгэл нэмэгддэг байна.

Хөдөө орон нутгаас ирсэн иргэдийн 47 хувь нь аймгийн⁷ төвийн багуудаас, 39 хувь нь сумын төвийн багуудаас, 14 хувь нь хөдөөгийн багуудаас⁸ ирсэн байв.

Бүдүүвч 2. Хөдөө орон нутгаас ирсэн хөдөлгөөний төрөл (эзлэх хувь)



Улаанбаатар хотын хэмжээнд 1,414 иргэн отор⁹ нүүдэл хийх зорилгоор ирсэн байна. Отор нүүдэл хийх зорилгоор ирэгсдийн дийлэнх буюу 33 хувь

Түүнчлэн Улаанбаатар хотод ирсэн иргэдийн 41 хувь нь орон сууц зонхилсон хэсгүүдээс, 23 хувь нь гэр хороолол болон орон сууц холимог хэсгүүдээс ирсэн бол үлдсэн 37 хувь нь гэр хороолол зонхилсон хэсгүүдээс ирсэн байна.

Бүдүүвч 1. Ирсэн хөдөлгөөний төрөл (эзлэх хувь)



Бүдүүвч 3. Улаанбаатар хот доторх ирсэн хөдөлгөөний төрөл (орон байрны төрөл)



нь Сонгинохайрхан дүүрэгт ирсэн бол үүний араас Баянзүрх дүүрэг (26 хувь), Сүхбаатар дүүрэг (12 хувь) тус бүр орсон байна.

⁷ Аймаг гэдэг нь хөдөө орон нутгийг тодорхойлох засаг захиргааны дээд нэгж


⁸ Баг нь хөдөө орон нутаг дахь засаг захиргааны хамгийн жижиг нэгж

⁹ Отор нь хол газар удаан хугацаагаар малаа маллан нүүдэллэх


Зураг 16. Отор нүүдлээр ирсэн хөдөлгөөн хамгийн их бүртгэгдсэн дүүргүүд (эзлэх хувь)




Зураг 17. Сонгинохайрхан дүүрэгт отор нүүдлийн үндсэн шалтгаанаар ирсэн иргэд хамгийн их бүртгэгдсэн хороод (эзлэх хувь)




Зураг 18. Баянзүрх дүүрэгт отор нүүдлийн үндсэн шалтгаанаар ирсэн иргэд хамгийн их бүртгэгдсэн хороод (эзлэх хувь)




Зураг 19. Сүхбаатар дүүрэгт отор нүүдлийн үндсэн шалтгаанаар ирсэн иргэд хамгийн их бүртгэгдсэн хороод (эзлэх хувь)



Зураг 20. Баянгол дүүрэгт отор нүүдлийн үндсэн шалтгаанаар ирсэн иргэд хамгийн их бүртгэгдсэн хороод (эзлэх хувь)



Зураг 21. Хан-Уул дүүрэгт отор нүүдлийн үндсэн шалтгаанаар ирсэн иргэд хамгийн их бүртгэгдсэн хороод (эзлэх хувь)



Отор нүүдлээр ирсэн иргэдийн үндсэн шалтгаан нь улирлын чанартай хөдөлгөөнд оролцох (отор нүүдэл хийх үндсэн шалтгаанаар ирэгсэдтэй хэсгүүдийн 57 хувийн мэдээлснээр) байгаа бол үүний дараа энэ хэсэг дэх бэлчээрийн гарц илүү сайн гэсэн шалтгаан бүртгэгдсэн байна.


Эхний шатны үнэлгээгээр Улаанбаатар хотын хэмжээнд ирсэн иргэдийн үндсэн шалтгаан нь гэр

бүл байсан бол энэ удаагийн үнэлгээгээр үндсэн шалтгаан нь үйлчилгээний хүртээмж байсан Багахангай дүүргээс бусад бүх дүүрэгт ирэх үндсэн шалтгаан нь боловсрол байв. Мөн хөдөлмөр эрхлэлт, орон байр гэсэн шалтгаанууд зонхилж байна. Харин гэр бүлийн шалтгаан бүх хэсгүүдийн ердөө 11 хувьд зонхилж байжээ.

Зураг 22. Отор нүүдлийн үндсэн шалтгаан (эзлэх хувь)



Зураг 23. Отор нүүдлийн бус шилжилт хөдөлгөөнд оролцох болсон үндсэн шалтгаан (эзлэх хувь)



Хүснэгт 2. Ирсэн үндсэн шалтгаан (дүүргээр)

● Отор нүүдэл хийх зорилгоор ирэх шалтгаан ● Ирэх шалтгаан, отор нүүдлийн бус

НИЙТ	Баянзүрх дүүрэг	Сонгинохайрхан дүүрэг	Баянгол дүүрэг	Хан-Уул дүүрэг
Улирлын чанартай хөдөлгөөн/ Боловсрол	Улирлын чанартай хөдөлгөөн Боловсрол	Улирлын чанартай хөдөлгөөн/ Боловсрол	Улирлын чанартай хөдөлгөөн/ / Боловсрол	Улирлын чанартай хөдөлгөөн/ / Боловсрол
Чингэлтэй дүүрэг	Сүхбаатар дүүрэг	Налайх дүүрэг	Багануур дүүрэг	Багахангай дүүрэг
Явсан газар бэлчээрийн гарц байхгүй	Явсан газар бэлчээрийн гарц байхгүй	Улирлын чанартай хөдөлгөөн ба энэ хэсэг дэх бэлчээрийн гарц илүү сайн	Энэ хэсэг дэх бэлчээрийн гарц илүү сайн	Улирлын чанартай хөдөлгөөн
Боловсрол	Боловсрол	Боловсрол	Боловсрол	Үйлчилгээний хүртээмж

1.4 ЯВСАН ХӨДӨЛГӨӨН

Тоон мэдээлэл нэгтгэх судалгааны хоёр дугаар үе шат эхлэхээс өмнөх гурван сарын хугацаанд Улаанбаатар хотоос 23,103 иргэн явсан нь нэг дүгээр ээлжийн үнэлгээний 85,428 иргэн явсан үзүүлэлтээс мэдэгдэхүйц буурсан үзүүлэлттэй байна.¹⁰ Явсан иргэдийн хамгийн өндөр хувь нь Сонгинохайрхан (23 хувь), Баянзүрх (17 хувь), Хан-Уул дүүрэгт (14 хувь) бүртгэгдсэн бол өмнөх үнэлгээнд энэ үзүүлэлт Сонгинохайрхан дүүрэг (25 хувь), Сүхбаатар дүүрэг (18 хувь) ба Чингэлтэй дүүрэг (16 хувь) гэж бүртгэгджээ.

Явсан иргэдийн дийлэнх буюу 80 хувь нь Улаанбаатар хотын өөр дүүрэг рүү, 16 хувь нь дүүргийнхээ өөр хороо/хэсэг рүү, 4 хувь нь хөдөө орон нутаг руу явжээ. Хөдөө орон нутаг руу явагсдын 56 хувь аймгийн төвийн баг руу, 30 хувь нь хөдөөгийн баг руу, 14 хувь нь сумын баг руу явсан байна. Харин Улаанбаатар хотын өөр дүүрэг, хороо/хэсэг рүү явсан иргэдийн 55 хувь нь орон сууц зонхилсон хэсгүүд рүү, 25 хувь нь гэр хороолол болон орон сууц холимог хэсгүүд рүү, 20 хувь нь гэр хороолол зонхилсон хэсгүүд рүү нүүжээ.

¹⁰ Явсан иргэд гэдэг нь Улаанбаатар хотын аль байршлыг орхиж явснаас үл хамааран хотын нэг цэгээс нөгөө цэгрүү, эсвэл орон нутаг, гадаад улс оронд явсан иргэд, айл өрхийг хэлнэ. Мөн түүнчлэн энэхүү тоон мэдээлэл нь хэсгийн ахлагчийн мэдлэг, тандалт судалгаан дээр үндэслэн тооцоолсон тоо тул бодит тоон мэдээллээс зөрүүтэй байх боломжтой юм.


Зураг 24. Явсан хөдөлгөөн хамгийн их бүртгэгдсэн дүүргүүд (эзлэх хувь)




Бүдүүвч 4. Явсан хөдөлгөөний төрөл (эзлэх хувь)



Бүдүүвч 5. Хөдөө орон нутагруу явсан хөдөлгөөний төрөл (эзлэх хувь)




Бүдүүвч 6. Улаанбаатар хот дотрох явсан хөдөлгөөний төрөл (орон байрны төрөл)



Ирсэн иргэдийн нэгэн адилаар Улаанбаатар хотын хэмжээнд явсан иргэдийн явах шалтгаануудад гэр бүлийн шалтгаан зонхилохгүй байв. Орон сууцанд амьдрах гэсэн үндсэн шалтгаантай Чингэлтэй дүүргээс бусад бүх дүүргүүдэд явах үндсэн шалтгаан боловсрол эзэмших байжээ. Түүнчлэн бусад чухал шалтгаануудад орон сууцанд амьдрах, хөдөлмөр эрхлэх, шаардлагатай үйлчилгээнд ойртох багтсан байна. Харин орон байртай холбоотой саад бэрхшээл, хөдөлмөр эрхлэх, шаардлагатай үйлчилгээндээ ойртох нь бусад шалтгаануудад багтжээ.

Зураг 25. Явсан хөдөлгөөний үндсэн шалтгаан (эзлэх хувь)



Хүснэгт 3. Явсан шалтгаан (дүүргээр)

Нийт	Баянзүрх дүүрэг	Сонгинохайрхан дүүрэг	Баянгол дүүрэг	Хан-Уул дүүрэг
Боловсрол	Боловсрол	Боловсрол	Боловсрол	Боловсрол
Чингэлтэй дүүрэг	Сүхбаатар дүүрэг	Налайх дүүрэг	Багануур дүүрэг	Багахангай дүүрэг
Орон сууц, газар эзэмших асуудал	Боловсрол	Боловсрол	Боловсрол	Боловсрол Үйлчилгээний хүртээмж

1.5 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Зураг 26. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбарууд (хэсэгт эзлэх хувь)



Улаанбаатар хотын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбар нь барилгын салбар (хэсгүүдийн 25 хувийн мэдээлснээр) байсан ба өмнөх үнэлгээний дүнтэй харьцуулбал барилгын салбар хэсгүүдийн 24 хувьд хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбар байсан. Хөдөлмөр эрхлэлтийн бусад үндсэн салбараар бусад үйлчилгээ (24 хувь), бөөний болон жижиглэнгийн худалдааг (17 хувь) нэрлэсэн байна. Энэ үзүүлэлтээс харвал өмнөх үнэлгээгээр хотын хэмжээнд бөөний болон жижиглэнгийн худалдаа (29 хувь) үндсэн салбар байсан бол энэ удаагийн үнэлгээгээр энэ үзүүлэлт харьцангуй буурсан харагдаж байна.


Хүснэгт 4. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбар (дүүргээр)

НИЙТ	Баянзүрх дүүрэг	Сонгинохайрхан дүүрэг	Баянгол дүүрэг	Хан-Уул дүүрэг
Барилга (25%) Бусад үйлчилгээ (24%) Бөөний болон жижиглэн худалдаа (17%)	Барилга (23%) Бусад үйлчилгээ (22%) Бөөний болон жижиглэн худалдаа (21%)	Барилга (36%) Бусад үйлчилгээ (23%) Бөөний болон жижиглэн худалдаа (10%)	Бусад үйлчилгээ (33%) Бөөний болон жижиглэн худалдаа (10%) Барилга (12%)	Барилга (24 хувь) Бусад үйлчилгээ (24%) Төрийн удирдлага ба батлан хамгаалах (9%)
Чингэлтэй дүүрэг	Сүхбаатар дүүрэг	Налайх дүүрэг	Багануур дүүрэг	Багахангай дүүрэг
Барилга (29%) Бөөний, жижиглэн худалдаа (29%) Бусад үйлчилгээ (18%)	Барилга (23%) Бусад үйлчилгээ (25%) Бөөний, жижиглэн худалдаа (17%)	Бусад үйлчилгээ (28%) Барилга (16%) Төрийн удирдлага ба батлан хамгаалах (8%)	Уул уурхайн олборлолт (32%) Бусад үйлчилгээ (16%) Барилга (6%)	Бусад (67%) Боловсрол (17%) Бусад үйлчилгээ (17%)

1.6 САНХҮҮГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Улаанбаатар хотын бүх дүүргүүдэд орлогын үндсэн эх үүсвэр нь хөдөлмөр эрхлэлт гэж мэдээлсэн ба энэ үзүүлэлт хэсгүүдийн 88 хувьд зонхилж байна. Түүнчлэн орлогын бусад эх үүсвэрт тэтгэвэр (6 хувь), төрийн болон ТББ-аас өгдөг халамж, тусламж (2 хувь), хувиараа хөдөлмөр эрхлэлт (1 хувь), байшин газраас авсан түрээсийн орлого (1 хувь) орж байна.

Харин нийт 35 хэсэг дийлэнх оршин суугчдынх нь орлогын үндсэн эх үүсвэр нь төрийн болон ТББ-аас өгдөг халамж, тусламж гэсэн мэдээлэл өгсөн байна. Эдгээр хэсгүүд нь Чингэлтэй (9 хэсэг), Баянзүрх (8 хэсэг), Налайх (4 хэсэг), Баянгол (4 хэсэг), Хан-Уул (5 хэсэг) дүүрэгт байсан.

Зураг 27. Орлогын үндсэн эх үүсвэр (эзлэх хувь)

Хүснэгт 5. Орлогын үндсэн эх үүсвэр (дүүргээр)

	Хөдөлмөр эрхлэлт	Тэтгэвэр	Төрийн болон ТББ-аас өгдөг халамж, тусламж	Хувиараа хөдөлмөр эрхлэлт	Байшин, газраас авсан түрээс
Нийт	88%	6%	2%	1%	1%
Баянзүрх	89%	5%	2%	2%	1%
Сонгинохайрхан	91%	5%	0%	1%	1%
Баянгол	88%	7%	2%	0%	1%
Хан-Уул	92%	3%	2%	0%	1%
Чингэлтэй	82%	8%	5%	0%	3%
Сүхбаатар	87%	9%	1%	2%	1%
Налайх	80%	8%	8%	2%	0%
Багануур	68%	10%	16%	0%	3%
Багахангай	100%	0%	0%	0%	0%

Сүүлийн 6 сарын хугацаанд хүнсний хэрэглээ мэдэгдэхүйц хэмжээгээр буюу хэсгүүдийн 68 хувьд хүрч буурсан ба үүнд хүнсний хэрэглээ тогтмол байдлаар буурсан үзүүлэлттэй хэсгүүдийн 12 хувь орсон болно (нийт 218 хэсгээс). Энэ нь нийтдээ Улаанбаатар хотын хэмжээнд 196,933 хүнд нөлөөлөл үзүүлжээ (хотын нийт хүн амын 12 хувь). Сонгинохайрхан дүүрэгт хамгийн олон хэсэг (74 хэсэг буюу тус дүүргийн нийт хэсгийн 20 хувь) хүнсний хэрэглээгээ мэдэгдэхүйц тогтмол байдлаар бууруулсан үзүүлэлттэй байна.

Зураг 28. Хүнсний хэрэглээгээ багасгасан (эзлэх хувь)



Хүснэгт 6. Хүнсний хэрэглээгээ тогтмол байдлаар бууруулсан хэсгүүд (дүүргээр)

НИЙТ	Баянзүрх АҮҮРЭГ	Сонгинохайрхан АҮҮРЭГ	Баянгол АҮҮРЭГ	Хан-Уул АҮҮРЭГ
218 хэсэг	52 хэсэг	74 хэсэг	21 хэсэг	33 хэсэг
Чингэлтэй АҮҮРЭГ	Сүхбаатар АҮҮРЭГ	Налайх АҮҮРЭГ	Багануур АҮҮРЭГ	Багахангай АҮҮРЭГ
9 хэсэг	17 хэсэг	9 хэсэг	3 хэсэг	0 хэсэг

1.7 ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНТЭЙ ХОЛБООТОЙ ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДЛУУД

Улаанбаатар хотод шилжин ирж буй иргэдийн нөлөөллөөс улбаатай хамгийн ихээр тулгамддаг асуудалд төрийн үйлчилгээ, онцолбол боловсролын үйлчилгээний ачаалал (хэсгийн 29 хувийн мэдээлснээр) болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ачаалал (хэсгийн 16

хувийн мэдээлснээр) орсон. Багахангай, Багануур дүүргүүдээс бусад бүх дүүрэгт боловсролын үйлчилгээтэй холбоотой бэрхшээл хамгийн чухал байсан бол Баянгол дүүрэгт хамгийн өндөр хувьтай байжээ (34 хувь).

Зураг 29. Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тулгамдаж буй асуудлууд (эзлэх хувь)




Хүснэгт 7. Ирсэн хөдөлгөөнтэй холбоотой тулгамдаж буй асуудлууд (дүүргээр)

	Боловсролын хүртээмж	Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээм	Замын хөдөлгөөн түгжрэл	Байгаль орчны бохирдол	Агаарын бохирдол	Гэмт хэрэг	Нийгмийн чиг хандлага	Цөлжилт
Нийт	29%	16%	15%	14%	13%	4%	2%	1%
Баянзүрх	27%	18%	17%	12%	11%	5%	4%	0%
Сонгино хайрхан	26%	16%	11%	16%	15%	7%	1%	0%
Баянгол	34%	21%	19%	11%	6%	3%	3%	0%
Хан-Уул	33%	14%	18%	14%	16%	2%	1%	1%
Чингэлтэй	25%	18%	11%	17%	14%	5%	1%	2%
Сүхбаатар	31%	9%	13%	13%	18%	2%	1%	1%
Налайх	29%	9%	5%	15%	9%	7%	2%	2%
Багануур	20%	27%	13%	13%	20%	3%	0%	0%
Багахангай	0%	20%	0%	20%	20%	0%	0%	0%

Улаанбаатар хотын хэмжээнд хэсгүүдийн 60 хувь нь засаг захиргааны нэгжээс шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авч ажилласан гэж мэдээлсэн бол 12 хувь нь ямар ч арга хэмжээ авч ажиллаагүй гэж мэдээлжээ.

Засаг захиргаанаас одоогийн байдлаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдээс гадна богино хугацааны хөдөлгөөнийг бүртгэх эрх зүйн орчныг сайжруулах (гол мэдээлэгчдийн 63 хувь), улмаар төвлөрсөн бүсийн орох, гарах хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулах (гол мэдээлэгчдийн 24 хувь) асуудлыг эрх баригчид анхаарах нь зүйтэй гэж гол мэдээлэгчид үзсэн байна.

Зураг 30. Засаг захиргааны нэгжээс арга хэмжээ авч байгаа эсэх (эзлэх хувь)



Зураг 31. Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх боломжтой бусад арга хэмжээ (эзлэх хувь)




1.8 ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ БА ДЭД БҮТЭЦ

Улаанбаатар хотын хэмжээнд иргэдэд хамгийн хүндрэлтэй байгаа асуудлаар орлогоо нэмэгдүүлэх боломж бололцооны хомсдол (хэсгүүдийн 17 хувь мэдээлсэн), эрүүл мэндийн барилга байгууламж, тусламж үйлчилгээний ачаалал (16 хувь), боловсролын үйлчилгээний ачаалал (14 хувь), машины зогсоол (13 хувь) гэсэн асуудлыг нэрлэсэн

байна. Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Налайх дүүргүүдэд орлогоо нэмэгдүүлэх боломж бололцооны хомсдол; Багануур, Багахангай дүүргүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ачаалал; Хан-Уул дүүрэгт боловсролын үйлчилгээний ачаалал иргэдэд тулгамддаг хамгийн чухал бэрхшээл байжээ.

Зураг 32. Хангалттай хүртээмжгүй байгаа үйлчилгээ (эзлэх хувь)



Хүснэгт 8. Иргэдэд хүртээмжгүй байгаа үндсэн үйлчилгээ болон дэд бүтэц (дүүргээр)

	Орлогоо нэмэгдүүлэх боломж	Эрүүл мэнд	Боловсрол	Машины зогсоол	Орон байр	Ундны ус	Цахилгаан эрчим хүч	Хүнс
Нийт	17%	16%	14%	13%	7%	6%	5%	3%
Баянзүрх	16%	16%	16%	14%	6%	5%	6%	1%
Сонгино хайрхан	16%	15%	11%	10%	7%	6%	9%	5%
Баянгол	16%	16%	19%	20%	5%	3%	3%	3%
Хан-Уул	14%	15%	16%	12%	6%	5%	4%	4%
Чингэлтэй	17%	14%	11%	11%	12%	7%	5%	3%
Сүхбаатар	19%	14%	15%	15%	8%	7%	3%	2%
Налайх	21%	20%	9%	5%	8%	8%	9%	4%
Багануур	16%	23%	16%	4%	10%	5%	4%	8%
Багахангай	28%	33%	0%	0%	17%	0%	6%	0%

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж буй үндсэн бэрхшээлээр нийтийн эзэмшлийн зам, талбай, барилга байгууламжид аюулгүй нэвтрэхэд шаардлагатай дэд бүтцийн дутмаг байдлыг

(хэсгүүдийн 36 хувь мэдээлсэн) нэрлэсэн бол үүний араас тусгайлсан эмнэлгийн тусламж үйлчилгээ (25 хувь), тусгайлсан тээврийн үйлчилгээ (23 хувь) орсон байна.

Зураг 33. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж буй асуудлууд (эзлэх хувь)



Хүснэгт 9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж буй асуудал (дүүргээр)

	Нийтийн эзэмшлийн талбайд аюулгүй нэвтрэх дэд бүтэц	Тусгайлсан эмнэлгийн тусламж үйлчилгээ	Тусгайлсан тээврийн үйлчилгээ	Тусгайлсан боловсролын үйлчилгээ	Бусад	Ямар ч сорилт байхгүй
Нийт	36%	25%	23%	12%	1%	3%
Баянзүрх	36%	25%	24%	13%	0%	2%
Сонгино хайрхан	37%	25%	24%	10%	1%	3%
Баянгол	43%	23%	16%	17%	0%	0%
Хан-Уул	33%	23%	26%	11%	2%	5%
Чингэлтэй	30%	27%	25%	12%	1%	5%
Сүхбаатар	38%	28%	22%	9%	0%	2%
Налайх	23%	26%	38%	5%	2%	7%
Багахангай	24%	20%	20%	25%	2%	9%
Багануур	0%	83%	0%	0%	0%	17%

ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ

ХҮН АМЫН СУУРЬ ТООН ҮЗҮҮЛЭЛТ БА БҮРТГЭЛ

Үнэлгээг хийх үед (2022 оны 6, 7, 8-р саруудад) Улаанбаатар хотод 1,591,375 иргэн, 462,276 өрх амьдарч байгаа нь нэг өрхийн ам бүл дунджаар 3-4 (3.44) гишүүнтэй байна. Нийслэлийн нийт хүн амын 53 хувь нь эмэгтэй, 47 хувь нь эрэгтэй байна. Хүн амын 34% нь 18 ба түүнээс доош насны хүүхдүүд, 57 хувь нь 18-59 насны насанд хүрэгчид, 8 хувь нь 60 ба түүнээс дээш насны ахмадууд эзэлж байна.

Нийслэлийн хэмжээнд нийт хэсгийн 42 хувьд иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэл 90 хувьд хүрсэн ба үүнд бүх оршин суугчид нь бүртгүүлсэн 7 хувь буюу 124 хэсэг багтсан. Хамгийн өндөр буюу 100 хувь бүртгэл Багахангай дүүрэгт байсан (хэсгүүдийн 17 хувийн мэдээлснээр). Хэсгүүдийн 3 хувь нь оршин суугчдын 40-өөс бага хувь нь бүртгүүлсэн гэж мэдээлсэн ба үүнд нэг ч оршин суугч бүртгүүлээгүй 6 хэсэг багтсан болно. Нийт дүүргүүдэд оршин суугчид өөрсдийгөө түр зүүр оршин сууж байгаа гэж үзэн бүртгүүлэх хүсэлгүй байгаа нь бүртгэл хийлгэхгүй байх үндсэн шалтгаан болж байна.

ШИЛЖИН ИРЭГСЭД БА ЯВАГСАД

Улаанбаатар хотод мэдээлэл нэгтгэхээс өмнөх гурван сарын байдлаар нийслэлд 47,309 иргэн шилжин ирж, 23,103 ирсэн явсан байна. Энэ тоо баримтаас харахад нийт шилжин ирэгсдийн тоо явсан иргэдийн тооноос илүү тоологдсон байна. Гэвч дүүрэг хоорондын эсхүл дүүрэх доторх хөдөлгөөний тоон мэдээлэл шилжин ирэгсэд, явагсдын гол мэдээллийг бүрдүүлдэг гэдгийг анхаарах нь зүйтэй (шилжин ирэгсдийн 86 хувь, шилжин явагсдын 96 хувь).

Хамгийн олон шилжин ирэгсдийг мэдээлсэн гурван дүүрэгт Сонгинохайрхан (22 хувь), Баянзүрх (21 хувь), Хан-Уул (19 хувь) тус бүр орсон байна. Багахангай дүүрэгт шилжин ирэх үндсэн шалтгаан шаардлагатай үйлчилгээндээ ойртох байсан бол нийслэлийн бусад дүүргүүдэд шилжин ирэх үндсэн

шалтгаан боловсрол байв. Өмнөх судалгаанд зонхилж байсан гэр бүлийн шалтгаан нь энэ удаагийн судалгаанд зөвхөн 11 хэсэгт зонхилсон. Түүнчлэн 1,414 иргэн отор нүүдлийн зорилгоор ирсэн ба энэ нь улирлын чанартай хөдөлгөөнтэй холбоотой юм (57 хувь).

Хамгийн олон шилжин явагсадтай гурван дүүрэгт Сонгинохайрхан (23 хувь), Баянзүрх (17 хувь), Хан-Уул (14 хувь) орсон байна. Ирсэн хүмүүсийн нэгэн адилаар нийслэлийн хэмжээнд шилжин явсан шалтгаан нь гэр бүлийн шалтгаанаас боловсролтой холбоотой шалтгаан руу шилжсэн байна. Орон сууц зонхилсон хэсгүүдэд рүү нүүх гэсэн шилжин явах гол шалтгаантай Чингэлтэй дүүргээс бусад бүх дүүргүүдэд иргэдийн дийлэнх нь боловсролын шалтгаанаар шилжин явсан байв.

ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ; ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ДЭД БҮТЭЦ

Улаанбаатар хотын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбар нь барилгын салбар (хэсгийн 25 хувийн мэдээлснээр) байсан бол өмнөх судалгааны дүнгээр бүх дүүргүүдэд зонхилж байсан бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарын хувь энэ удаа мэдэгдэхүйц буурсан үзүүлэлттэй байна (29 хувиас 17 хувь).

Нийслэлийн бүх дүүргүүдэд орлогын үндсэн эх үүсвэр хөдөлмөр эрхлэлт байсан. Гэвч хотын хэмжээнд 35 хэсэгт (нийт хэсгийн 2 хувь) дийлэнх иргэд орлогын эх үүсвэр нь төрийн болон ТББ-аас өгдөг халамж, тусламж гэж хариулжээ. Эдгээр хэсгүүд Чингэлтэй (9 хэсэг), Баянзүрх (8 хэсэг), Налайх (4 хэсэг), Баянгол (4 хэсэг), Баянгол (5 хэсэг) дүүрэгт байна.

Сүүлийн зургаан сарын хугацаанд нийт 218 хэсэг (хэсгүүдийн 12 хувь нь) оршин суугчид нь хүнсний хэрэглээгээ бууруулсан ба энэ нь 196,933 хүнд нөлөөлөл үзүүлсэн гэж мэдэгджээ. Сонгинохайрхан дүүрэгт хүнсний хэрэглээгээ тогтмол байдлаар бууруулсан хамгийн олон хэсэг байсан (74 хэсэг

буюу тус дүүргийн нийт хэсгийн 20 хувь).

Ирсэн иргэдийн хөдөлгөөнтэй холбоотой Улаанбаатар хотод шилжин ирэхэд хамгийн ихээр тулгамдаж буй асуудлаар үйлчилгээний хүртээмж, үүнд нэн ялангуяа боловсролын үйлчилгээний ачаалал (хэсгүүдийн 29 хувийн мэдээлснээр) болон эмнэлгийн тусламж үйлчилгээний ачааллыг (16 хувь) нэрлэсэн. Багануур, Багахангай дүүргүүдээс бусад бүх дүүрэгт боловсролтой холбоотой бэрхшээл хамгийн ихээр тулгамдаж байсан. Хэсгүүдийн талаас илүү (60 хувь) нь эрх бүхий байгууллагуудаас шилжилт хөдөлгөөнтэй холбоотой богино хугацааны асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авч ажилласан гэж мэдээлсэн бол 12 хувь нь ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй гэжээ. Хотын хэмжээнд бараг бүх дүүргийн (Багануур, Багахангай дүүргүүдээс бусад) хэсгийн ахлагч нарын дийлэнх нь шилжин ирэгсдэд тулгамддаг бэрхшээлийг бууруулахад нэн тэргүүнд авах арга хэмжээ бол богино хугацааны хөдөлгөөнийг бүртгэх эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх нь зүйтэй гэжээ.

Бүх дүүргийн хэсгүүдийн 17 хувь нь орлогоо нэмэгдүүлэх боломж бололцоо дутмаг байгаа гэсэн нь хотын хэмжээнд зонхилох тулгамдсан асуудал юм. Түүнчлэн оршин суугчид эмнэлгийн барилга байгууламж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ачаалал (16 хувь), боловсролын барилга байгууламж, үйлчилгээний ачаалал (14 хувь), машины зогсоол (13 хувь) зэрэг бэрхшээлийг онцолсон байна. Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Налайх дүүргүүдэд орлогоо нэмэгдүүлэх боломж бололцоо хомс гэсэн бэрхшээл хамгийн чухал байсан. Нөгөөтээгүүр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгардаг хамгийн чухал асуудал нь тээврийн тусгай үйлчилгээ, тусгайлсан боловсролын байгууллага, тусгайлсан эмнэлгийн тусламж үйлчилгээ гэсэн Налайх, Багануур, Багахангай дүүргүүдээс бусад бүх дүүргүүдэд эдгээр иргэдэд тулгардаг хамгийн том асуудал бол нийтийн эзэмшлийн талбай, барилга байгууламжид аюулгүй нэвтрэх дэд бүтэц дутмаг байх гэжээ.

ЗӨВЛӨМЖҮҮД

Нийгэм-эдийн засгийн сорилтууд:

Улаанбаатар хотын хэмжээнд орлогоо нэмэгдүүлэх боломж хомс байх нь зонхилох бэрхшээл байсан. Дотоодын эдийн засгийг идэвхжүүлэх, нэн ялангуяа хувийн хэвшлийг идэвхжүүлэх замаар иргэдэд дэмжлэг үзүүлэх нь чухал. Аж үйлдвэрийн салбараас бусад салбаруудад жижиг, дунд бизнесүүдийг бий болгох, хөгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж дэмжихийг зөвлөж байна. Ингэхдээ оршин суугчдынх нь дийлэнх нь төрийн болон ТББ-аас тусламж, халамжийг орлогын үндсэн эх үүсвэр гэсэн хэсгүүдэд онцгой анхаарал хандуулах нь зүйтэй.

Хотын хэмжээнд нийт хэсгүүдийн 12 хувь өрхүүд хүнсний хэрэглээгээ бууруулсан гэж мэдээлсэн. Эмзэг бүлгийн өрхүүдийн амьдралын үндсэн хэрэгцээг хангахын тулд хүнсний багц тараах зэрэг богино хугацааны зорилтот тусламжийг хамгийн эмзэг/нэн ядуу өрхүүдэд үзүүлэх нь зүйтэй.

Улаанбаатар хотод шилжин ирэгсдэд тулгамддаг үндсэн бэрхшээл боловсролын үйлчилгээний хүртээмж байсан бол энэ бэрхшээл хотын хэмжээнд ирэгсдэд бол явагсдад тулгамддаг зонхилох асуудал байсан. Бүх дүүргүүдийн боловсролын барилга байгууламжийн чадамжийг бэхжүүлэхэд тулгамддаг саад бэрхшээлийг ойлгохын тулд илүү өргөн хүрээний судалгаа хийх нь зүйтэй.

Оршин сууж байгаа газартаа бүртгүүлэхгүй байх нь хотын хэмжээнд түгээмэл үзэгдэл хэвээр байна. Бүртгэлийн ажлыг хөнгөвчлөхийн тулд олон нийтэд бүртгэлийн тухай ойлголтыг түгээх ба бүртгэлийн үйл явцын тухай мэдлэгийг нь дээшлүүлэх нь зүйтэй

ХАВСРАЛТ



ХАВСРАЛТ А. ОРЛОГЫН ҮНДСЭН ЭХ ҮҮСВЭР НЬ ТЭТГЭВЭР ГЭЖ МЭДЭЭЛСЭН ХОРООД (ДҮҮРГЭЭР)

Баянзүрх дүүрэг

15-р хороо	3 хэсэг
20-р хороо	3 хэсэг
33-р хороо	3 хэсэг
11-р хороо	2 хэсэг
23-р хороо	2 хэсэг
40-р хороо	2 хэсэг
1-р хороо	1 хэсэг
4-р хороо	1 хэсэг
17-р хороо	1 хэсэг
22-р хороо	1 хэсэг
24-р хороо	1 хэсэг
29-р хороо	1 хэсэг
32-р хороо	1 хэсэг
34-р хороо	1 хэсэг
35-р хороо	1 хэсэг
38-р хороо	1 хэсэг
43-р хороо	1 хэсэг

Нийт **26 хэсэг**

Сонгинохайрхан дүүрэг

32-р хороо	5 хэсэг
21-р хороо	3 хэсэг
3-р хороо	2 хэсэг
40-р хороо	1 хэсэг
34-р хороо	1 хэсэг
6-р хороо	1 хэсэг
7-р хороо	1 хэсэг
9-р хороо	1 хэсэг
19-р хороо	1 хэсэг
26-р хороо	1 хэсэг
36-р хороо	1 хэсэг

Нийт **18 хэсэг**

Баянгол дүүрэг

3-р хороо	4 хэсэг
5-р хороо	3 хэсэг
12-р хороо	3 хэсэг
21-р хороо	1 хэсэг
26-р хороо	1 хэсэг
11-р хороо	1 хэсэг
23-р хороо	1 хэсэг
4-р хороо	1 хэсэг
8-р хороо	1 хэсэг

Нийт **16 хэсэг**

Сүхбаатар дүүрэг

19-р хороо	5 хэсэг
8-р хороо	4 хэсэг
20-р хороо	2 хэсэг
4-р хороо	1 хэсэг
13-р хороо	1 хэсэг
2-р хороо	1 хэсэг
11-р хороо	1 хэсэг
7-р хороо	1 хэсэг
18-р хороо	1 хэсэг

Нийт **17 хэсэг**

Чингэлтэй дүүрэг

8-р хороо	3 хэсэг
15-р хороо	3 хэсэг
10-р хороо	3 хэсэг
24-р хороо	2 хэсэг
4-р хороо	1 хэсэг
17-р хороо	1 хэсэг
2-р хороо	1 хэсэг
16-р хороо	1 хэсэг

Нийт **15 хэсэг**

Хан-Уул дүүрэг

8-р хороо	3 хэсэг
4-р хороо	1 хэсэг
12-р хороо	1 хэсэг
13-р хороо	1 хэсэг
14-р хороо	1 хэсэг

Нийт **7 хэсэг**

Налайх дүүрэг

4-р хороо	1 хэсэг
5-р хороо	1 хэсэг
6-р хороо	1 хэсэг
1-р хороо	1 хэсэг

Багануур дүүрэг

2-р хороо	2 хэсэг
3-р хороо	1 хэсэг

Нийт

4 хэсэг

Нийт

3 хэсэг

ХАВСРАЛТ Б. ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГААС ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНТЭЙ ХОЛБООТОЙ БОГИНО ХУГАЦААНЫ АСУУДЛЫГ ШИЙДЭХ АРГА ХЭМЖЭЭ АВЧ АЖИЛЛААГҮЙ ГЭЖ МЭДЭЭЛСЭН ХОРООД (ДҮҮРГЭЭР)

Баянзүрх дүүрэг

15-р хороо	6 хэсэг
43-р хороо	5 хэсэг
8-р хороо	4 хэсэг
30-р хороо	3 хэсэг
31-р хороо	3 хэсэг
37-р хороо	3 хэсэг
13-р хороо	2 хэсэг
21-р хороо	2 хэсэг
23-р хороо	2 хэсэг
25-р хороо	2 хэсэг
38-р хороо	2 хэсэг
2-р хороо	1 хэсэг
3-р хороо	1 хэсэг
6-р хороо	1 хэсэг
11-р хороо	1 хэсэг
12-р хороо	1 хэсэг
16-р хороо	1 хэсэг
19-р хороо	1 хэсэг
26-р хороо	1 хэсэг
40-р хороо	1 хэсэг
41-р хороо	1 хэсэг

Сонгинохайрхан дүүрэг

1-р хороо	4 хэсэг
13-р хороо	3 хэсэг
26-р хороо	3 хэсэг
21-р хороо	2 хэсэг
5-р хороо	2 хэсэг
29-р хороо	2 хэсэг
15-р хороо	1 хэсэг
37-р хороо	1 хэсэг
38-р хороо	1 хэсэг
2-р хороо	1 хэсэг
3-р хороо	1 хэсэг
19-р хороо	1 хэсэг
41-р хороо	1 хэсэг
14-р хороо	1 хэсэг
17-р хороо	1 хэсэг
22-р хороо	1 хэсэг
24-р хороо	1 хэсэг
32-р хороо	1 хэсэг
34-р хороо	1 хэсэг
36-р хороо	1 хэсэг

Нийт

44 хэсэг

Нийт

30 хэсэг

Баянгол дүүрэг

12-р хороо	3 хэсэг
22-р хороо	3 хэсэг
13-р хороо	3 хэсэг
26-р хороо	2 хэсэг
14-р хороо	2 хэсэг
4-р хороо	2 хэсэг
18-р хороо	2 хэсэг
29-р хороо	2 хэсэг
2-р хороо	1 хэсэг
8-р хороо	1 хэсэг
25-р хороо	1 хэсэг
11-р хороо	1 хэсэг
7-р хороо	1 хэсэг

Чингэлтэй дүүрэг

14-р хороо	6 хэсэг
15-р хороо	6 хэсэг
3-р хороо	6 хэсэг
5-р хороо	5 хэсэг
19-р хороо	3 хэсэг
12-р хороо	1 хэсэг
13-р хороо	1 хэсэг
4-р хороо	1 хэсэг
2-р хороо	1 хэсэг
7-р хороо	1 хэсэг
10-р хороо	1 хэсэг
17-р хороо	1 хэсэг
24-р хороо	1 хэсэг

9-р хороо	1 хэсэг		
10-р хороо	1 хэсэг		
20-р хороо	1 хэсэг		
Total	27 хэсэг	Total	34 хэсэг

Хан-Уул дүүрэг

5-р хороо	4 хэсэг	11-р хороо	7 хэсэг
20-р хороо	4 хэсэг	5-р хороо	6 хэсэг
10-р хороо	3 хэсэг	3-р хороо	6 хэсэг
16-р хороо	3 хэсэг	4-р хороо	5 хэсэг
14-р хороо	2 хэсэг	6-р хороо	5 хэсэг
2-р хороо	2 хэсэг	18-р хороо	3 хэсэг
8-р хороо	2 хэсэг	9-р хороо	3 хэсэг
1-р хороо	2 хэсэг	17-р хороо	2 хэсэг
23-р хороо	2 хэсэг	8-р хороо	1 хэсэг
12-р хороо	1 хэсэг	19-р хороо	1 хэсэг
24-р хороо	1 хэсэг		
22-р хороо	1 хэсэг		
Нийт	27 хэсэг	Нийт	39 хэсэг

Налайх дүүрэг

4-р хороо	3 хэсэг		
Нийт	3 хэсэг		




Уг тайлангийн үр дүн, дүгнэлт нь зөвхөн судалгааны багийн байр суурийг илэрхийлэх бөгөөд ОУШХБ, түүний гишүүн улсууд, Швейцарын хөгжлийг агентлаг болон бусад хандивлагчдын байр суурийг илэрхийлэхгүй болно. Тайлангийн туршид ашигласан тэмдэглэгээ болон материалын танилцуулга нь аливаа улс орон, нутаг дэвсгэр, хот, бүс нутгийн эрх зүйн байдлын талаар ОУШХБ-ын зүгээс ямар нэгэн үзэл бодол илэрхийлэх, эсхүл түүний эрх баригчид, хил хязгаарыг илэрхийлээгүй болно.

ОУШХБ нь шилжин суурьшигчид, хөдөлгөөнт хүн ам болон нийгэмд тустай, хүмүүнлэг, аюулгүй, цэгцтэй шилжилт хөдөлгөөний зарчмыг баримтлан ажилладаг. ОУШХБ нь засгийн газар хоорондын байгууллага, олон улсын хамтын нийгэмлэгийн түншүүдтэйгээ дараах зорилтын хүрээнд хамтран ажилладаг. Үүнд: Шилжилт хөдөлгөөний үйл явц дахь сорилтыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, шилжилт хөдөлгөөний асуудлын талаар мэдлэг мэдээллээ дээшлүүлэх, шилжилт хөдөлгөөнөөр дамжуулан нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих, мөн шилжин суурьшигчдын нэр төр, сайн

сайхныг дээдлэх зэрэг болно.

Энэхүү тайлан нь Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэйгээр, ОУШХБ-аас хэрэгжүүлж буй “Монгол Улс дахь дотоод шилжилт хөдөлгөөнийг ойлгож, удирдах нь” төслийн хүрээнд хийгдэж буй ажлуудаас гаргаж буй үр дүнгийн нэг хэсэг юм. Энэхүү төслийн зорилго нь Хүн амын Хөдөлгөөнийг Тандах Матрицыг (ДТМ) ашиглан Монгол Улсын дотоод шилжилт хөдөлгөөн, хөгжлийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх замаар нотолгоонд суурилсан томьёолол, хэрэгжилтийг бэхжүүлэн бататгахад оршино. Тайланг загварчлах, дүн шинжилгээ хийх ажлыг Ямэй Дү, дотоодын зөвлөх Ганбатын Гэрэлтогтохын хамт боловсруулсан болно. Судалгааны асуулгын загварчлалыг ОУШХБ-ын ДТМ-ын баг, НЗДТГ-ын оролцоотойгоор боловсруулсан байна. Судалгааны мэдээллийг ОУШХБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн алба болон Глобал ДТМ-ийг дэмжих багийн техникийн дэмжлэгтэйгээр Хүн амын Хөдөлгөөнийг Тандах Матрицын (ДТМ) хэрэглүүрийг ашиглан цуглуулж, дүн шинжилгээ хийсэн болно. дүн шинээ хий болно.



Swiss Agency for Development and Cooperation SDC
Швейцарын хөгжлийн агентлаг